БНМАУ

# УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 11 сарын 14 № 331 Улаанбаатар хот

Монгол лифт компани бай-
гуулах тухай

БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн тухай хуулийг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

I. Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 230 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтыг үндэслэн Улаанбаатар хотын лифтийн засвар үйлчилгээний конторыг үйлдвэрлэл үйлчилгээний Монгол лифт компани /ХХК/ болгон зохион байгуулсугай.

2. Монгол лифт компани /ХХК/-ын дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1990 оны 104 дүгээр тогтоолын I-р заалтын "Улаанбаатар хотын лифт засвар үйлчилгээний контор болгон ажиллуулсугай" гэсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА Л.ЭНЭБИШ

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Д.БОЛДСАЙХАН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА

Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны 1991 оны 231 дугаар тогтоолын хавсралт.

# "МОНГОЛ ЛИФТ" КОМПАНИЙН ДҮРЭМ.

/ҮҮГ/

Компаний оноосон нэр: "МОНГОЛ ЛИФТ"

Компаний хаяг: БНМАУ-ын Улаанбаатар хот Сүхбаатарын дүүрэг, гудамж Найрамдалын 26

Нэг. Компаний эрхлэх ажил: Улсын хэмжээний иргэний орон сууцны болон бусад зориулалтын бүр төрлийн лифтэнд техникийн үйлчилгээ, тохиргоо засвар угсралтын ажлуудыг гүйцэтгэнэ

Компани нь лифтийн техникийн үйлчилгээ, засварын ажил гүйцэтгэхээс гадна тоног төхөөрөмжийн жижиг үйлдвэрлэл явуулах үйлчилгээ, үйлдвэрлэлийн хавсарсан байгууллага байх юм.

Хоёр. Ажлын үндсэн чиглэл зорилго:

1. Лифтийн засвар техникийн үйлчилгээний чанарыг сайжруулах техникийн найдвартай ажиллагааг хангахад онцгой анхаарч ажиллана.

2. Засвар үйлчилгээний хэрэгцээг судлан хэтийн төлөв үйлчилгээний норм норматив тоног төхөөрөмж сэлбэг хэрэгслэлийн элэгдэлийн нормыг тогтоох мэргэжлийн дүгнэлт гарган ажиллана.

3. Аваар осолгүй ажиллах талаар ашиглагч байгууллага, иргэдийг сурталчилгаа мэдээллээр үйлчилнэ.

4. Бүх төрлийн лифтэнд техникийн үйлчилгээ засварын ажлыг гүйцэтгэхийн дээр шаардлагатай зарим лифтийн сэлбэгийг дотооддоо үйлдвэрлэх зорилт тавьж ажиллана.

Гурав. Ажиллах зарчим:

1. Өөрөө өөрийгөө санхүүжүүлэн аж ахуйн тооцоон дээр ажиллана.

2. Лифтийн техникийн үйлчилгээ засварын ажлаар байгууллагуудтай аж ахуйн гэрээ байгуулж гүйцэтгэх ажил үйлчилгээний нэр, төрөл, тоо хэмжээ засварын үйлчилгээний ажлын чанар дээшлүүлэх сэлбэг материалын нөөцийг хамрах зэрэг хоёрийн үйл ажиллагаанаас шууд хамаарах үзүүлэлтүүдийн дагуу засвар үйлчилгээний нэгж хө-

4. Ажил үйлчилгээнд батлагдсан тарифыг мөрдөнө.

5. Ажилтан, ажилчдад цалин хөлс олгохдоо улсын хэмжээнд мөрдөж байгаа тарифт мэргэжлийн зэрэглэлийг баримтална.

6. Нэг мэргэжилтэн мөрдөх хийтэйн журмыг ажилчдын тийсэн хөр-гийн цалинтайн осолттой нь уялдуулан тогтоож мөрдүүлнэ.

7. Компанийн санхүүгийн хөрөнгө, ажил үйлчилгээний орлого, зо-ойн үр дүнтэй уялдуулан зарцуулагдах цалин хөлсийг өсгөх, буур-уулах арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлнэ.

8. Компани нь улсын татварын нэгдсэн бодлогын дагуу олсон ашгаасаа татвар төлнө.

9. Үйлдвэрлэх бүтээгдэхүүний төр төрөл, чанарыг дээшлүүлэ-хийн тулд гадаадын пүүс, хороо, байгууллагатай хоршиж, хамтран ажиллах хэлбэрийг өргөжүүлнэ.

10. Компани технологи, техник нэвтрүүлэхэд гадаадын патент лицензийг ашиглах, техникийн мэдээллийг цаг алдалгүй хийхэд банкны зээл, валютын зээл ашиглах болно.

11. Компани нь ажил үйлчилгээ, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн мэдээ, балансыг холбогдох газруудад тогтоосон журмын дагуу тогтмол гаргана.

12. Бусад компанийн өмнө хүлээх хүлээлх, түүний хувьцаа эзэл-жийг худалдан авах эрхтэйгээр компанийн хөрөнгийг хэсэгчлэн бу-сдад нь худалдах, захиран зарцуулна.

13. Бусад эд ахуйн нэгжийн зээлийг, санхүүгийн, хувьцаа, эр, гэ-рээ хэлцлийн мөнгөн төлбөрийг төлөх талаар баталгаа гаргаж өгнө.

14. Компанид ашигтай нөхцөлөөр бусдад мөнгө зээлдүүлнэ.

15. Хуулийн дагуу төлөх ёстой компанийн бүх зардал, түүнийг байгуулах, бүртгэх болон бүртгүүлэх, эзэмших бүх хувьцааг хуваарил-сан брокерийн зардал мөн компанийн эрх мэдлээ хэтрүүлснээс үүдэн гарах хохирол зэргийг олсноос зардлыг төлнө.

16. Компанийн дүрэм журамд түс нэмэр болно гэж үзэх бусад бүх эрхийг хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Д. Хөрөнгө, санхүү:

1. Компанийн үндсэн хөрөнгийг өөрийн хөрөнгө, банкны урт хуга-цааны зээлийн хөрөнгөөр бүрдүүлнэ.

2. Үндсэн хөрөнгийн нөхөн үйлдвэрлэлийг банкны зээл, өөрийн хөрөнгөөр хангана./ нэгдэл, хоршоодын гишүүд/

цаатай зээлийн хөрөнгөөр бүрдүүлнэ.

2.Үндсэн хөрөнгийн нөхөн үйлдвэрлэлийг банкны зээл,өөрийн хөрөнгөөр хангана./Элэгдэл хорогдлын шимтгэл/

Компанийн орлого нь

а/ аж ахуйн гэрээний ажлын орлого

б/илүүдэл бүтээгдэхүүний борлуулалтын орлого зэргээс бүрдэнэ.

3.Компани нь төсвийн орлогыг бүрдүүлэхэд оролцож улсаас тогтоогдсон татварыг төлнө

4.Ур ашгийг дээшлүүлэхэд хамт олны сонирхолыг өндөржүүлэн үйлдвэрлэл үйлчилгээний материаллаг баазыг бэхжүүлэх хамт олны нийгмийн асуудлыг шийдвэрлэх хөрөнгийг бий болгоно.

5.Компани нь эд хөрөнгийн талаар БНМАУ-ын хууль тогтоомжид заасан эрхийг эдэлнэ.

<u>Тав.Үйлдвэрлэл удирдлагын зохион байгуулалтын бүтэц:</u>

1.Компани нь техник төхөөрөмжөөр тоноглогдсон үйлдвэрлэлийн цех лифтийн үйлчилгээ засварын ажил гүйцэтгэх хэсгүүд аваарын дуудлагын шуурхай үйлчилгээний албатай байна.

2.Компанийг удирдах дээд байгууллага нь удирдах ажилтны зөвлөлгийн хурал байх бөгөөд түүний чөлөө цагт компанийн бүрэн эрхийг ерөнхий захирал хэрэгжүүлнэ.

3.Компанийн захиралыг шууд харьяалах дээд байгууллага нь гэрээний үндсэн дээр томилно.

4.Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг захирал удирдаж ажилчдын өмнө хариуцан тайлагнана.

5.Компанийн захирал БНМАУ-ын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал заавар гаргана.Тушаал заавврыг компанийн хүрээнд мөрдөнө

6.Компанийн захирал дор дурдсан үүрэг хүлээж эрх эдэлнэ

а/Компанийн нэрийн өмнөөс бусад байгууллага иргэнтэй шууд харилцаж хөдөлмөр иргэний болон бусад гэрээ байгуулж хэлцэл хийнэ.

б/Компанийн эд хөрөнгийг БНМАУ-ын хууль тогтоомж компанийн гэрээ дүрэмд заасны дагуу захиран зарцуулна

в/Тайлан тэнцэл болон компанийн эд хөрөнгийн талаарх мэдээ тайлааг хариуцаж компанийн үйл ажиллагааны талаар ажилчдад мэдээлнэ.

г/Компанаас гаргасан мэдээ мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

д/Компаний захиргааны бусад албан тушаалтан болон салбар нэгжийн даргыг томилж чөлөөлнө.

е/Ажилтнуудыг хууль тогтоомжинд заасны дагуу ажилд авах, халах

7.Компанийн дотоод бүтэц зохион байгуулалтыг компанийн удирдах ажилтны зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

8.Компанийн үйлдвэрлэл техникийн зөвлөл удирдах ажилтны зөвлөл гэсэн хоёр зөвлөлтэй байх бөгөөд үйлдвэрлэл техникийн зөвлөл нь техникийн эшиглэлт аюулгүй жигд ажиллагаатай холбоотой асуудлыг,удирдах ажилтны зөвлөл нь дотоод гадаад хамтын ажиллагаа аж ахуй санхүү захиргааны холбоотой бусад асуудлыг хариуцна

9.Үйлдвэрлэл техникийн зөвлөл нь сард 4 удаа удирдах ажилтны зөвлөл нь 2 удаа нэг гуравдугаар долоо хоногуудад хуралдаж байна.

Зургаа.Компанийн ажиллагсадын эрх,үүрэг:

1.Ажиллагсад нь компанитай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллахын дээр компанийн дүрэм дотоод журам гэрээний заалтыг бүрэн биелүүлэх үүрэгтэй.

2.Ажиллагсад нь хариуцсан ажилдаа удаа дараа гомдол гарган ажил тасалах,техникийн аюулгүй ажиллагааны дүрэм зөрчих,ажлын цагаар архи уух хэв журмын зөрчилд орох зэрэг хөдөлмөрийн гэрээг зөрчвөл хөдөлмөрийн хуулийн 58-р зүйлд заасанаар арга хэмжээ авч хариуцлага тооцно.

3.Сахилгын шийтгэлийг зөвхөн ажилтанг ажилд авах ажлаас халах эрх бүхий албан тушаалтан оногдуулна

4.Ажилтанд сахилгын шийтгэл оногдуулсан хугацаанд сар улирал жилийн ажиллагааны үр дүнгийн шагналт цалин болон шагнал урамшил олгохгүй.

Компанийн ажиллагсад нь БНМАУ-ын хөдөлмөрийн хуулинд заасан эрхийг эдэлнэ.

Долоо.Компанид ажилтанг авах,халах:

1.Иргэдийг ажилд авахдаа дор дурдсан бичиг баримтыг үндэс болгоно.Үүнд:

а/Тогтоосон журмын дагуу хөтлөгдсөн хөдөлмөрийн дэвтэр, ажил эрхлээгүй байсан бол оршин суугаа орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах байгууллагын тодорхойлолт,албан шилжүүлэг

б/Хаягийн бүртгэл хийгдсэн иргэний паспорт

в/Тусгай мэргэжил,мэдлэг шаардагдах ажил албан тушаалд орох хүнээс боловсролын буюу мэргэжлийн үнэмлэх диплом шаардана

2.Дараах тохиолдолд компаниас ажилтныг халнa Үүнд:

а/ Өөрөө гарахаар өргөдлөө өгсөн

б/Ажилтан нас барсан сураггүй алга болсон

в/Компанийн дүрмийн заалт хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй зөрчсөн тохиолдолд

3.Компаниас халах шалтгаан үндэслэлийг захиргааны шийдвэрт заасны дагуу хөдөлмөрийн дэвтэрт нь бичнэ

4.Захиргаа ажлаас халагдсан ажилтанд хөдөлмөрийн хуулийн 18-р зүйлийн нэгдэх хэсгийн 6,20-р зүйлийн нэгдэх хэсгийн 3,5-д зааснаас бусад тохиолдолд нэг сараас доошгүй хугацааны дундаж сарын цалинтай тэнцэх тэтгэмж олгоно.

<u>Найм.Дотоод гадаад хоршилт хамтын ажиллагаа:</u>

I.Гадаадын ижил төрлийн үйлдвэр үйлчилгээний газруудтай БНМАУ-ын хууль тогтоомжинд заасан эрхийн хэмжээнд шууд харилцах эрхийг эдэлнэ

2.Компани нь материал техникийн хангамжийн талаар үйлдвэр аж ахуй хангамжийн байгууллагуудтай гэрээ байгуулж ажиллана.

<u>Ес.Компанийг байгуулах,татан буулгах:</u>

I.Компанийг шууд харьяа дээд байгууллага Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны шийдвэрээр байгуулж татан буулгана.

2.Компани нь тогтоогдсон журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

3.Компани нь Монгол лийт гэсэн нэр тэмдэг албан бичгийн баланк хэрэглэнэ.

4.Компанийг доор дурдсан үндэслэлээр татан буулгана

а/засвар үйлчилгээ эрэлт хэрэгцээгүй болсон

б/санхүүгийн алдагдалтай болж төлбөрийн чадваргүй болсон